

## АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ШУУРХАЙ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2017.04.10

№ 07

Дархан

Аймгийн Засаг даргын шуурхай хурал 2017 оны 04 дүгээр сарын 10-ний өдрийн 08 цаг 00 минутад Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хурлын зааланд хуралдав. Хуралдааныг аймгийн Засаг даргыг орлогч Т.Ганболд дарга удирдав. Хуралд Тамгын газрын дарга Ч.Энхбат, ТЗУХ-ийн дарга П.Баярсайхан, ХЭЗХ-ийн дарга Л.Алтанчимэг, ХОХБТХ-ийн ахлах мэргэжилтэн М.Энхбаяр, НБХ-ийн дарга Н.Цасчихэр, ХШҮДАХ-ийн дарга Д.Жаргалсайхан, СТСХ-ийн дарга Б.Жаргалсайхан, Цэргийн штабын дарга Ц.Энхтөр, МТА-ны дарга Х.Соёл-Эрдэнэ, НҮА-ны дарга Б.Дамдинбазар, Дархан сумын Засаг даргын Тамгын газрын дарга О.Хүрэлчулуун, Хонгор сумын Засаг даргын орлогч Б.Лхагвасүрэн, Орхон сумын Засаг даргын орлогч Б.Түмэнцогт, МХГ-ын дарга Д.Бат-Эрдэнэ, Цагдаагийн газрын төлөвлөлт, зохион байгуулалтын тасгийн дарга Г.Мэндбаяр, ОБГ-ын дарга Г.Батбаяр, Татварын хэлтсийн хяналт шалгалтын тасгийн дарга Т.Бат-Очир, Захирагчийн албаны дарга Э.Равжаадэлгэрэх, ГХБХБГ-ын дарга Д.Ганбаяр, Орон нутгийн өмчийн газрын дарга Б.Батсүх, СХААлбаны дарга Б.Баасанжаргал, НААҮГ-ын дарга Ж.Дорждэрэм нар хуралд оролцов.

### ХУРАЛДААНААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ:

1. Хэлтэс, агентлагийн 7 хоногийн ажлын тайлан, холбогдох мэдээ мэдээллийн талаарх тайланг танилцуулах.
2. Шуурхай хурлаар өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийн талаарх тайланг танилцуулах

Хуралдаанаар хэлтэс, агентлагийн дарга нар 7 хоногийн мэдээ, мэдээлэл, үйл ажиллагааны тайланг танилцуулж, мэдээлэл хийлээ.

### ХУРАЛДААНААС ӨГӨГДСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР:

Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга Ч.Энхбат:

№	Өгөгдсөн үүрэг даалгавар	Хариуцах эзэн	Хэрэгжилт
1.	“Төр, нийгмийн түншлэл 2017” зөвлөгөөнөөс гарсан санал санаачлагыг хэрэгжүүлэх, хамтран ажиллах санамж бичиг, гэрээнд тусгагдсан ажлуудыг ажил хэрэг болгох талаар онцгойлон анхаарч зөвлөгөөнөөс гарсан шийдвэрүүд, үр дүнгээ өгч, хэрэгжиж байгаа талаар олон нийтэд таниулах, мэдээллэх хэрэгтэй байна.	НБХ, ХОХБТХ, МТА	- “Төр, нийгмийн түншлэл 2017” зөвлөгөөн, хүлээж буй үр дүнгийн талаар аймгийн аймгийн ЗДТГ-ын дарга Ч.Энхбаттай ярилцлага хийв. Тус ярилцлагыг Монголын мэдээ, Дарханы мэдээ сонины сонинд тус тус нийтлүүлсэн. Ярилцлагыг цахим хуудсаар олон нийтэд сурталчилсан.  - Төрийн бус байгууллагуудаас төсөл хүлээн авах хэвлэлийн бага хурал зохион байгуулж, мэдээллийг олон нийтэд хүргэсэн.
2.	Эрүүл мэндийн газраас зохион байгуулж байгаа	НБХ	- Амралтын өдөр буюу энэ сарын 15-ны өдөр аймгийн Эрүүл мэндийн газраас

	<p>“Нээлттэй хаалганы өдөр”-ийг өндөр түвшинд зохион байгуулах одооноос бэлтгэл ажлыг хангах, амралтын өдөр зохион байгуулж байгаа учраас иргэд олноор ирж, маш их оочир дараалал үүснэ. Энэ байдлыг иргэдэд чирэгдэлгүйгээр яаж зохион байгуулах талаар анхаарах мөн Эрүүл мэндийн яамнаас холбогдох албан тушаалтныг урьж, аймгийн удирдлагуудыг оролцуулах гэх мэт томоохон ажлуудыг зохион байгуулах шаардлагатай байна.</p>		<p>зохион байгуулсан сувилагчийн өдөрлөгийн үйл ажиллагааг сурвалжилж олон нийтэд сурталчилсан.</p>
3.	<p>ХОХБТХ хурлын дараа Хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын нээлтийн арга хэмжээг зохион байгуулах тухай хөтөлбөр, төлөвлөгөөг яаралтай танилцуулах хэрэгтэй байна.</p>	ХОХБТХ	<p>- Хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын нээлтийн арга хэмжээний зураг авч мэдээлэл бэлтгэсэн. Мэдээллийг цахим хуудсаар сурталчилсан. Дарханы мэдээ сонины 4 дүгээр сарын сарын дугаарт онцолж мэдээлж байна. Мөн аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ-ийн дарга С.Баясгалантай 2017 оны хөрөнгө оруулалтын ажлуудын талаар сонины ярилцлага хийсэн.</p> <p>- Нээлтийн үйл ажиллагаанд зориулж 2012-2016 оны хөрөнгө оруулалт бүтээн байгуулалтын ажлуудаар видео танилцуулга бэлтгэсэн.</p>
4.	<p>04 дүгээр сарын 17-ны өдрөөс 21-ны өдрийн хооронд Дархан-Уул аймгийн урт хугацааны хөгжлийн цогц бодлогын баримт бичиг боловсруулах анхан шатны хэлэлцүүлгийг зохион байгуулах бэлтгэл ажлын төлөвлөгөөг тодорхой болгож саналаа танилцуулаарай.</p>	ХОХБТХ	
5.	<p>Able cloud програмын хэрэглээг нэмэгдүүлэх шаардлагатай байна МТА-наас 80 албан хаагч нэвтэрч орж ажиллаж байна гэсэн мэдээлэл өгсөн энэ нь хангалтгүй байна. Хэлтсүүд Able cloud програмыг бүрэн хэрэглэх талаар онцгой</p>	Аймгийг ЗДТГ-ыг хэлтсүүд, МТА	<p>Able cloud програмын хэрэглээг нэмэгдүүлэх талаар Мэдээллийн цагийн үеэр ЗДТГ-ын алба хаагчдад танилцуулсан.</p> <p>НҮГ, ХОХБТХ, МХГ-ын ажилтнуудад програм ашиглалтын талаар сургалт мэдээлэл өгсөн.</p>

	анхаарах хэрэгтэй.		
6.	Аймгийн Засаг даргын 2017-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, 2017 оны нийгэм, эдийн засгийн зорилтын хүрээнд аймгийн ЗДТГ-ын албан хаагчдын дунд АХА тэмцээнийг зохион байгуулсан уг тэмцээнийг агентлагууд дарга нар өөрийн байгууллагадаа мөн адил зохион байгуулж, зохион байгуулсан тухай тайлан мэдээг аймгийн ЗДТГ-т ирүүлэх хэрэгтэй байна. Энэ талаар албан ёсоор албан бичгээр хандана.	ТЗУХ, Бүх хэлтэс, агентлагийн удирдлагууд	
7.	Засаг даргын зөвлөлийн хурал, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлж байгаа бодлогын баримт бичгүүдийн боловсруулалтад анхаарч нягт нямбай шалгаж бодлогын хэлтсийн мэргэжилтнүүдэд хугацаанаас нь өмнө яаралтай өгөх шаардлагатай байна.	Бүх хэлтэс, агентлагийн удирдлагууд	
8.	НААҮГ хог цэвэрлэгээний ажлыг эрчимтэй зохион байгуулж байна. Одоо цэвэрлэсэн хогоо яаралтай ачих хэрэгтэй байна. Захирагчийн албаны дарга НААҮГ-т хог ачих машин тэрэгний дэмжлэг үзүүлэн бөөгнүүлсэн хогоо ачиж дуусгаарай.	ЗА, НААҮГ	
9.	Ерөнхийлөгчийн сонгууль болохтой холбогдуулан Сонгуулийн хороог байгуулах ажил удахгүй эхэлнэ. Уг сонгуулийн хороонд орж ажиллах албан хаагчдаа хуулийн дагуу ажлаас нь чөлөө олгож дотоод ажлаа зохицуулаарай.	Бүх хэлтэс, агентлагийн удирдлагууд	

Аймгийн Засаг даргын орлогч Т.Ганболд:

№	Өгөгдсөн үүрэг даалгавар	Хариуцах эзэн	Хэрэгжилт
1.	НБХ өрхийн амьжиргааны судалгааг хугацаанд нь гаргаж дуусгах талаар холбогдох арга хэмжээг авч ажиллаарай. Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээгээ сайжруулж, өдөр тутмын мэдээ мэдээллээ удирдлагуудад танилцуулж байгаарай.	НБХ	Аймгийн ХХҮГ-ын дарга С.Энхболдыг тодруулга ярилцлагад урьж, Өрхийн амьжиргааны судалгаандаа идэвхтэй хамрагдахыг уриалсан. Тус ярилцлагыг орон нутгийн 4 телевизээр цацуулсан.
2.	Дархан сум Сум хөгжүүлэх сангийн зээлийн талаарх мэдээллээ иргэд, аж ахуй нэгж байгууллагуудад нээлттэй хүргэх аймгийн МТА-тай сумдууд хамтарч ажиллах, Дархан сумын иргэдээс гарсан саналаа ХОХБТХ-т өгөөрэй.	Дархан сум	Сум хөгжүүлэх сангийн зээл авч эхэлсэн тухай, бүрдүүлэх материал шаардлагыг олон нийтэд мэдээллэсэн.
3.	Онцгой байдлын газар Орхон сумын зам эвдэрсэнтэй холбоотой хохирлын үнэлгээ тогтоосон тухай дүгнэлт гарсана уу? Цаашид ямар арга хэмжээ авч ажиллах, хэн засвар үйлчилгээ хийх талаар тодруулах хэрэгтэй байна.	Онцгой байдлын газар	
4.	7 хоног бүр шуурхай хурал дээр 330 дугаар ангиас албан хаагчид эрүүлжүүлэгдсэн, цагдаагийн албан хаагчтай сөргөлдсөн талаар мэдээлэл өгч байна. Энэ талаар 330 дугаар ангийн удирдлагад анхааруулж байна уу?. 330 дугаар ангитай хамтран арга хэмжээ авах шаардлагатай байна.	Цагдаагийн газар	
5.	Хонгор сум Тариаланчдын зөвлөгөөнөөс өмнө аймгийн удирдлагуудтай урьдчилан уулзалт хийж газар тариалангийн салбарт тулгамдсан асуудал, шийдвэрлэх арга замын талаар уулзаж, хэлэлцэн нэг санаа бодолтой уг арга хэмжээнд оролцох, ажлын уялдаа холбоотой байх	Хонгор сум	

	шаардлагатай байна. ХОХБТХ-тэй ярилцаад уулзалтыг мягмар эсвэл пүрэв гаригт зохион байгуулаарай. Мөн тариалалтын бэлтгэл ажлыг хангах, судалгаа, тооцоо гаргах талаар анхаарах шаардлагатай байна.		
6.	Малчдын зөвлөгөөн хийх бэлтгэл ажлыг сайтар хангаарай. Малын индексжүүлсэн даатгалын чиглэлээр сургалт, зөвлөгөөнийг уг зөвлөгөөнтэй хамтатгаад хийвэл зүгээр байна. ХОХБТХ, ХХААГ-тай хамтран дараа 7 хоногоос зохион байгуулах өдрийг тодорхой болгоорой.	ХОХБТХ, ХХААГ, Хонгор сум	
7.	Салхит багийн ЭМТ-ийн тоног төхөөрөмжийн талаарх тулгамдсан асуудлыг шийдвэрлэх талаар анхаарах хэрэгтэй байна.	НБХ	
8.	НААҮГ, ЗА хамтраад “Хог бол мөнгө, хог бол баялаг” арга хэмжээг маш зөв зохион байгуулж үр дүнтэй болсон. Энэ ажлын талаарх үр дүн болон оролцсон байгууллагуудад талархал илэрхийлээд иргэдэд мэдээ, мэдээллээ сайтар өгөх, сурталчилах хэрэгтэй байна.	ЗА	
9.	2017 оны хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын нээлтийн арга хэмжээнд анхаарах, ямар ажил хийх талаар мэдээллээ өгөх хэрэгтэй байна.	ХОХБТХ	
10.	Төсөл хөтөлбөрүүд хүн бүрт ирж байна. Бичиг хэргээрээ дамжуулаад хэн, хэзээ, хаана өгсөн талаар тодорхой бүртгэл хийх, ХОХБТХ, НБХ-үүд чиглэл чиглэлээрээ төсөл, хөтөлбөрүүдээ хүлээн авч бүртгээрэй. Мөн МТА-нд төсөл хөтөлбөрөө аль чиглэлээр, хэнд, яаж өгөх талаар иргэдэд мэдээлэл өгөх хэрэгтэй байна. /хэзээ, хэдэн тоот өрөөнд, ямар мэргэжилтэнд өгөх талаар, холбоо барих утас тодорхой байх/	ХОХБТХ, НБХ	

11.	ОНӨГ 5 сардаа багтаагаад тендерийн бүх ажлуудаа эхлүүлэх хэрэгтэй байна. Үнэлгээ хийхдээ анхаарах, гомдол, санал багатайгаар зохин байгуулах хэрэгтэй байна.	ОНӨГ	
12.	ГХБХБГ Дархан-Уул аймгийн Дархан сумын төв гудамжнуудын нэр байршил, хил заагийг тогтоох тухай тогтоолоо батлуулах хэрэгтэй байна. Ажлын хэсэг хурлаа хийгээд 4 сарын 14-ны өдөр ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлж батлуулахаар өгөөрэй.	ГХБХБГ	
13.	Татварын хэлтэс орон нутгийн орлогын бүрдүүлэлтэд анхаарах, авто машины үзлэг хэдэн хувьтай явагдаж байна. Энэ ажлын тухай мэдээллээ удирдлагуудад байнга мэдээллэх шаардлагатай байна.	Татварын хэлтэс	
14.	ХЭЗХ шинээр гарсан хууль, эрх зүйн актуудаа удирдах ажилтны зөвлөгөөн болгон дээр танилцуулж, мэдээлэл өгдөг байсан. Энэ тухай мэдээллээ тогтмол өгч байх хэрэгтэй.	ХЭЗХ	
15.	ААН байгууллагуудын цэвэрлэгээнд хяналт тавих МТА-тай хамтран байгууллага дээр нь очоод шаардлага тавиад иргэдэд мэдээлэх хэрэгтэй байна. Шугам сүлжээ хүлээлцэх ажлуудыг яаралтай хий!	ЗА, МТА	Нийтийн цэвэрлэгээний талаарх мэдээллийг цаг тухай бүр мэдээлж ажиллалаа.
16.	ТЗУХ дотоод сургалтуудаа хийх, шаардлагатай бол сургалтын хөтөлбөр гаргаад төсөв батлуулаад сургалт хийгээрэй.	ТЗУХ	
17.	Шуурхай хурал дээр өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг хэлтэс, агентлагууд 5 дахь өдөр ТЗУХ-т өгдөг байх хэрэгтэй байна.	Бүх хэлтэс, агентлаг	
18.	“Төр нийгмийн түншлэл 2017” зөвлөгөөнөөс гарсан саналуудаа ажил хэрэг болгох хэрэгтэй байна. Бас санамж бичгүүдэд гарын үсэг	ХОХБТХ, НБХ	

	зурсан, үйлдвэрлэл, дэд бүтэц, хот төлөвлөлт, хууль, эрх зүйн чиглэлээр ирүүлсэн санал, санамж бичгүүдийг надад танилцуулах, нийгмийн бодлогын чиглэлийн санамж бичгүүдийг А.Түвшинбат даргад өнөөдрийн дотор танилцуулах шаардлагатай байна.		
19.	Сумдууд малын вакцинжуулалтыг хийх, өвөл вакцинжуулалт хийж чадаагүй айл өрхүүдийн малыг вакцинжуулах хэрэгтэй байна.	ХХААГ, ОБГ, Дархан, Шарын гол, Хонгор, Орхон сум	

Хурал 09 цаг 11 минутад дуусав.

ТАНИЛЦСАН:

ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН  
ГАЗРЫН ДАРГА

Ч.ЭНХБАТ

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН  
ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН

А.СУВД-ЭРДЭНЭ

Жич: Шуурхай хурлаас өгөгдсөн үүрэг даалгаварын хэрэгжилтийг 7 хоног бүрийн баасан гаригт ТЗУХ-ийн мэргэжилтэн А.Сувд-Эрдэнэд цаасаар болон цахимаар /a.pearl\_1220@yahoo.com/ ирүүлнэ үү. Холбоо барих утас 99841772, 70371212